

## АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

**I. ӨРХ, ХҮН АМ:** Оны эцэст 15.2 мянган өрх, 54.4 мянган суурин хүн амтай байгаа нь урьд оноос өрхийн тоо 571 -ээр хүн амын тоо 578-аар тус тус өслөө. Нийт өрхийн 48.8 хувь нь сумын төвд, 51.2 хувь нь хөдөөд амьдарч байна. Нийт өрхийн 73.9 хувь нь гэрт, 26.1 хувь нь орон сууцанд амьдарч байгаа бөгөөд 95.8 хувь нь хувийн, 4.2 хувь нь төрийн өмчийн болон төрийн бус өмчийн сууцанд амьдарч байна.

Хүн амын 51.2 хувь нь хөдөө, 48.8 хувь нь аймаг сумын төвд амьдарч байна. Нийт хүн амын 50.03 хувь нь эмэгтэйчүүд, 68.2 хувь нь 0-34 насны хүүхэд, залуучууд, 26.6 хувь нь 35-59 насны хүн, 5.3 хувь нь 60 болон түүнээс дээш настан байгаагийн 47 нь 90 ба түүнээс дээш настан байна. Хүн амын цахим мэдээллийн сангийн жилийн эцсийн зарим үзүүлэлтээс дурьдвал: Хүн ам зүйн ачаалал 54.3 хувьтай байна. 7-оос дээш насны 47498 хүн байгаагийн 6.8 хувь нь дээд, 4.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 2.4 хувь нь мэргэжлийн анхан шатны, 19.0 хувь нь бүрэн дунд, 25.2 хувь нь бага боловсролтой, 17.4 хувь нь боловсролгүй хүн байна.

66 багаар өрх хүн амын тоог авч үзвэл: Хамгийн олон хүнтэй баг нь Баруун-Урт сумын 5-р баг 781 өрх, 2622 хүнтэй байгаа нь Асгат, Наран, Халзан, Түмэнцогт сумын өрх, хүн амаас тус тус илүү байгаа бөгөөд хамгийн цөөн өрх, хүн амтай баг нь Халзан сумын Сахиулын шанд баг 70 өрх 270 хүнтэй байна.

2009 онд 626 гэр бүл, гэрлэлтээ бүртгүүлсэн байна.

Энэ онд 514 хүн шилжин ирсэн нь урьд оноос 100 хүнээр илүү байгаа бөгөөд 1409 хүн гадагш шилжин явсан нь урьд оноос цөөн байна. Шилжин явагсдын 61.2 хувь нь Улаанбаатар хот руу шилжсэн байна. Нийт өрхийн 12.6 хувийг эмэгтэйчүүд, 10.5 хувийг эрэгтэйчүүд дангаар тэргүүлж байна.

**II. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 4446.8 сая төгрөг орж, төлөвлөгөө 20.7 хувиар давж урьд оноос 646.2 саяар өссөн байна. Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 98.0 хувиар биелж, урьд оноос 1.0 тэрбумаар өссөн байна.

Улсын төвлөрсөн төсвийн байгууллагын санхүүжилтэнд 13728.6 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн байна.

**III. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Монгол шуудан, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 13002.4 сая төгрөгт хүрсэн нь 2008 оны жилийн эцсийнхээс 223.2 саяар буурсан байна.

Банкуудад иргэдийн хадгалуулсан хадгаламжийн хэмжээ 7363.2 сая төгрөг болж, 2008 оны мөн үеийнхээс 18.6 хувь буюу 1153.6 сая төгрөгөөр өссөн байна.

**IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Мал аж ахуй : Оны эцэст 10.1 мянган тэмээ, 131.5 мянган адуу, 110.1 мянган үхэр, 853.7 мянган хонь, 684.3 мянган ямаа тоологдож нийт 1789.7 мянган малтай болж 2008 оныхоос 247.2 мянган малаар таван төрөл дээр нь өсгөж, аймаг байгуулагдсан 1942 оноос хойшхи 68 жилд хамгийн олон 40.4 мянган тэмээг 1953 онд, 194.7 мянган адууг 2003 онд, 211.3 мянган үхрийг 1999 онд тоолуулж байсан бөгөөд энэ жил бүх мал, хонь, ямааны тоо хамгийн өндөр байна.

Урьд оноос бүх сум малаа өсгөсний дотор Эрдэнэцагаан, Түмэнцогт сумд тэмээнээс бусад 4 төрөл дээр нь, бусад 11 сум 5 төрөл дээр нь малаа өсгөлөө.

Аймагтаа 237.3 мянган мал, 109100 хонь, 98863 ямаагаар Баяндэлгэр сум, 1287 тэмээгээр Сүхбаатар сум, 22551 адуу, 19401 үхрээр Эрдэнэцагаан сум тэргүүлж байна.

Малын тоог багаар авч үзвэл: Нийт багийн 21.2 хувь нь 40.0 мянгаас дээш малтай, 15.2 хувь нь 10 мянгаас доош малтай байгаа бөгөөд хамгийн олон малтай нь Баяндэлгэр сумын 4-р баг 60.6 мянга, Баруун-Урт сумын 8-р баг 58.2 мянга, Онгон сумын 1-р баг 56.4 мянган малаар тус тус тэргүүлж байна.

Нийт малын 43.2 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Оны эхний эх малын 86.8 хувь болох 593.7 мянган эх мал төллөж, гарсан төлийн 97.9 хувь буюу 594.1 мянган төл бойжууллаа.

Нийт өрхийн 59.8 хувь болох 9.1 мянган өрх аминдаа 1765.7 мянган мал тоолуулсан нь нийт малын 98.7 хувийг эзэлж байна.

Нийт малтай өрхийн 67.9 хувийг 200 хүртэл малтай өрх эзэлж харин 500-аас дээш малтай өрх 8.9 хувийг эзэлж байна.

Энэ жил 175 малчин өрх 1000-аас дээш мал тоолуулсны дотор 1500-аас дээш малтан 18 байгаа бөгөөд 26 мянгат малчнаар Эрдэнэцагаан сум тэргүүлж байна.

Оны эхний малын 1.5 хувь болох 22.7 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 17 дахин цөөн байна.

**Газар тариалан:** Энэ жил үр тариа 100 га-д, төмс төмс 42.2 га-д, хүнсний ногоо 20.03 га-д тариалж, 60.0 тн үр тариа, 366.4 тн төмс, 176.0 тн хүнсний ногоо тус тус хураан авсан байна.

Хадлан 7222.0 тн, гар тэжээл 1026.5 тн, тэжээлийн ургамал 18.8 тн-ыг бэлтгэв.

**Малын индексжүүлсэн даатгал төсөл** тус аймагт хэрэгжиж, даатгалын 4 компани 273 малчин өрхийн 47.3 мянган малыг даатгалд хамруулан 17.9 сая төгрөгийг хураамжийн төлбөрт оруулсан байна.

**V. АЖ ҮЙЛДВЭР :** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 33.9 тэрбум төгрөг болж урьд оноос 242.2 сая төгрөгөөр бага байна.

Оны үнээр 101.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оноос 34.9 хувиар өссөн байна. Гол нэр төрлөөс талх, нарийн боов, эсгий, өнгөт тоосго, дулаан үйлдвэрлэлт нэмэгдсэн байна.

**VI БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО:** Барилга: Энэ жил барилгын байгууллагууд 1750.2 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь урьд оноос 1.2 хувиар буурсан байна. Шинээр 17 барилга ашиглалтанд оруулсан байна.

**Тээвэр:** Тээвэр бүхий байгууллагууд 54874.6 мян.тн км ачаа эргэлт, 7210.0 мян. хүн км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэн, 6.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 11.5 хувиар өссөн байна.

**Холбоо** ашиглалтын орлого 333.1 сая төгрөг байгаагийн дотор хүн амаас 145.3 сая төгрөг орсон нь урьд оны мөн үеэс нийт орлого нь 25.1 хувиар, хүн амаас орох орлого 26.5 хувиар тус тус буурсан байна. Телефон цэгийн тоо урьд оноос 20.3 хувиар өслөө.

**VII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 5.9 хувиар өссөнд самралт чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнээс бусад бүх бүлгийн барааны үнэ тариф 2.7-21.6 хувь болтлоо өссөн нь нөлөөлжээ

**VIII. БОЛОВСРОЛ,СОЁЛ:** 2009-2010 оны хичээлийн жилд 366 бүлэгт 10.6 мянган хүүхэд суралцаж байгаагийн 49.6 хувь нь эмэгтэй сурагчид байна.

1-р ангид 1.1 мянган хүүхэд элсэн орж, бага ангид 5.9 мянга, дунд ангид 3.8 мянга, ахлах ангид 1.0 мянган хүүхэд суралцаж байна. 2.4 мянган хүүхэд шалгагдан төгссөн байна. Энэ жил 15 сургуульд 869 хүн ажиллаж байгаагийн 514 буюу 59.1 хувь нь үндсэн багш байна.

**Соёл:** Хөгжимт жүжгийн театр 24.3 мянган үзэгчдэд 83 тоглолтоор үйлчилж 12.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

**Музей:** 1.8 мянган үзэмрээр 1.2 мянган хүнд үзүүлж 637.3 мянган төгрөгийн орлого олж, 59.8 сая төгрөгийн зардалтай ажилласан байна.

**Нийтийн номын сан:** 25.6 мянган уншигчдад 41.2 мянган номоор үйлчилж 374.1 мянган төгрөгийн орлого олж, 38.4 сая төгрөгийн зардал гаргасан байна.

**IX. ЭРҮҮЛ МЭНД:** 1192 эх амаржсан нь урьд оноос 154-өөр нэмэгдсэн бөгөөд 1 хүртэлх насандаа 22 хүүхэд эндсэн нь урьд оноос 2-оор цөөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 904 болж, урьд оноос 400-гаар буурсан байна.Урьд оноос вируст гепатит, бруцеллёз, тэмбүү өвчнүүд өссөн байна.

**X. АЖИЛГҮЙЧҮҮД:** ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1041 болж, урьд оноос 49.6 хувиар өссөн бөгөөд 68.3 хувь нь 16-34 насны залуучууд, 38.2 хувь нь бүрэн дунд, 18.8 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. 3416 хүн шинээр бүртгүүлж, 3218 хүн ажилд орсон байна..

**XI. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ:** Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3604.6 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 97.8 хувиар биелүүлсэн байна.

Сайн дурын даатгалд 1480 хүнийг хамруулахаас 879 хүн хамрагдаж, төлөвлөгөө 59.4 хувиар биелэв.

6068 өндөр настанд 6150.5 сая төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 5.6 мянган хүнд 1082.5 сая төгрөгийн төрөл бүрийн хөнгөлөлт, тэтгэвэр, тэтгэмж, Улсын төсвөөс 697.6 сая төгрөгийг хүүхдэд, 182.0 сая төгрөгийг шинээр төрсөн хүүхдэд, 400.5 сая төгрөгийг шинэ гэр бүлд, Хүүхэд хөгжил сангаас 1931.2 сая төгрөгийг тус тус олгосон байна. Нийт 2 хүнд 1.9 сая төгрөгийг олгож, нөхөн олговор авагчдаас 1 хүн хасагдсан байна.

**XII. ГЭМТ ХЭРЭГ** : Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 200 болж, урьд оны түвшинд байна. Гэмт хэргийн улмаас 36 хүн нас барж, 39 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 154.8 сая төгрөгийн хохирол учирсны 126.9 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 228 хүн холбогдон сэжиглэгдсэний 46.5 хувь нь бүлэглэнгээр, 16.2 хувь нь согтуугаар хэрэг үйлдсэн байна.

Нийт 2656 эрүүлжигдсэн нь урьд оноос 489 хүнээр цөөн байна.